



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 06 сарын 22-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Компанид “Гоёо Ноолуур” ХХК-ийг нэгтгэх тухай

“Говь” ХК (“Компани”) нь тус Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05-р сарын 29-ний өдрийн 12 тоот тогтоолын дагуу “Гоёо” ХХК-ийн нийт хувьцааны 100 хувийг бүрдүүлэх хувьцааг худалдан авснаар “Гоёо” ХХК-ийн нийт хувьцааг эзэмшдэг болохыг;

“Гоёо” ХХК нь тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06-р сарын 28-ны өдрийн 1 тоот “Компанийг тусгаарлаж зарим эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх тухай” тогтоолын дагуу тусгаарлаж, “Гоёо Ноолуур” ХХК-ийг шинээр үүсгэн байгуулсан бөгөөд Компанийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дах хэсэгт заасны дагуу “Гоёо” ХХК нь “Гоёо Ноолуур” ХХК-ийн хувьцааны нийт 100 хувийг бүрдүүлэх хувьцааг эзэмшдэг болохыг;

Дээр дурдсанчлан Компани нь “Гоёо Ноолуур” ХХК-ийн хувьцааны нийт 100 хувийг бүрдүүлэх хувьцааг шууд бусаар эзэмшдэг болохыг;

Компанид “Гоёо Ноолуур” ХХК-ийг нэгтгэхэд Компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн болохыг тус тус тэмдэглэн Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дах хэсгийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Гоёо” ХХК-аас тусгаарлаж, шинээр үүсгэн байгуулагдсан “Гоёо Ноолуур” ХХК-ийг Компанид нэгтгэхийг зөвшөөрсүгэй.
2. “Гоёо Ноолуур” ХХК-ийн үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг “Говь” ХК-д шилжүүлсүгэй.
3. Компанид “Гоёо Ноолуур” ХХК-ийг нэгтгэх журмыг Хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоолын дагуу Компанид “Гоёо Ноолуур” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан “Гоёо Ноолуур” ХХК-ийн санхүүгийн тайлан, бүртгэл болон нэгтгэх баланстай холбоотой ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэхийг “Говь” ХК-ийн Санхүү хариуцсан захирал /Г.Сэлэнгэ/-д, холбогдох өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх ажлыг “Говь” ХК-ийн Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/, өмгөөллийн “Авинекс партнерс” ХХН-д тус тус үүрэг болгосугай.



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 он 06 сар 30 өдөр

Дугаар18

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

У.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН





MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 он 06 сар 30 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН





КОМПАНИД “ГОЁО НООЛУУР” ХХК-ИЙГ НЭГТГЭХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар “Говь” ХК (“Компани”)-д “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулж “Гоёо ноолуур” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоох, Компанид түүний үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотойгоор Компанийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. КОМПАНИ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАГДАХ

- 2.1 “Гоёо ноолуур” ХХК-ийн үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг Компанид шилжүүлж, “Гоёо ноолуур” ХХК-ийн үйл ажиллагааг зогсооно.
- 2.2 Компанид “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 (гурван) өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо (“Хороо”) болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад энэ тухайгаа мэдэгдэнэ.
- 2.3 Хороо Компанийн “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрсөн бол уг бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 2.4 Компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлэх ажлыг Компани хариуцан зохион байгуулна.
- 2.5 “Гоёо ноолуур” ХХК-ийг улсын бүртгэлээс хассанаар Компанийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.
- 2.6 “Гоёо ноолуур” ХХК улсын бүртгэлээс хасагдсанаар түүнийг татан буугдсанд тооцох бөгөөд энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

Гурав. КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1 “Гоёо ноолуур” ХХК-ийн үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлснээр Гоёо ноолуур” ХХК-ийн төлөөгүй буюу дутуу төлсөн татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх Компанид шилжинэ.
- 3.2 Компанид “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор Компани нь зээлдүүлэгчид болон бусад харилцагчдад өөрчлөн байгуулагдсан тухайгаа бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:
 - 3.2.1 Компанид “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэсэн тухай;
 - 3.2.2 Компанийн оноосон нэр, байршил; болон
 - 3.2.3 нэгтгэх тухай шийдвэр гарсан огноо.
- 3.3 Компанид “Гоёо ноолуур” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэр гарсны дараа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчид хариуцан зохион байгуулна.

Дөрөв. БУСАД

- 5.1 “Гоёо ноолуур” ХХК-ийн үйл ажиллагааг шилжүүлсэнтэй холбоотойгоор тус компанийн ажилтан Компанид ажиллах болсон тохиолдолд Компани ажилтантай ижил хугацаа, нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулна.
- 5.2 “Гоёо ноолуур” ХХК-ийг Компанид нэгтгэсэн нь энэ журмын 5.1-д заасан ажилтны Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу эдлэх аливаа эрхийг хөндөхгүй байна.